



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2021 оны 04 сарын 22 өдөр

Дугаар E/28

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

Монгол ардын намыг тараах үндэслэл
бүрдсэнийг мэдэгдэх тухай

Миний бие Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшин сонгогдож, Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний болон хуулиар олгогдсон бусад бүрэн эрхийг хуулийн дагуу хэрэгжүүлэн өнөөг хүртэл ажиллаж байна.

Энэ хугацаанд Монгол ардын нам үнэмлэхүй олонхоор улиран засаглаж, тус намаас сонгогдсон Ерөнхий сайдууд, Улсын Их Хурлын дарга нар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүнээр надтай хамт ажиллаа.

Аливаа улс төрийн нам “улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” эрхэм зорилгын хүрээнд төрийн аюулгүй байдлыг сахиж, нийгмийн ашиг сонирхол, гишүүд, дэмжигчдийнхээ үзэл бодол, итгэл үнэмшлийн үндсэн дээр Үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэн биелүүлж ажиллах үүрэгтэй.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, холбогдох бусад хуулиар тавигдаж буй шаардлага бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт улс төрийн намын үүрэг, зорилгыг тодорхой зааж, мөн зүйлийн 4.2 дахь хэсэгт Монгол Улс ямар намыг хүлээн зөвшөөрөхгүйг, хүлээн зөвшөөрөхгүйгээс гадна хориглохыг тусгайлан хуульчилсан байдаг.

Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших 29 жилийн 21 жилд нь Монгол ардын нам төрийн эрхийг барьж, төрийн байгууллагуудыг удирджээ.

Энэ хугацаанд Монгол ардын нам Монгол Улсын Үндсэн хууль болон Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт огт нийцэхгүй үйл ажиллагааг удаа дараа явуулж ирсний зэрэгцээ сүүлийн үед цэрэгжсэн намын бүтэц, зохион байгуулалтын хэлбэрт шилжиж, цаашид цэргийн үйл ажиллагаа ч явуулж мэдэх хэмжээнд хүрсэн байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг орон даяар зохион байгуулж хангах үндсэн үүрэгтэй Монгол Улсын Засгийн газар Монгол ардын намын

2021000306

шийдвэрээр нэг өдрийн дотор огцордог, Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих үндсэн үүрэг бүхий Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Монгол ардын намын шийдвэр, зөвшөөрөлгүйгээр хуралдаж чадахаа болиод байна.

Үүнийг би Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувиар нотлон, уг намыг Улс төрийн намын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу тараах үндэслэл бүрдсэн хэмээн үзэж, Монгол Улсын дээд шүүхэд мэдэгдэн, хуульт ёсны дагуу шийдвэрлүүлэхээр захирамжилж, холбогдох баримт, материалыг хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Монгол ардын нам улс төрийн намын үйл ажиллагаанд чанд мөрдөгдөх “төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх” Үндсэн хуулийн шаардлагыг зөрчсөн үйл ажиллагаа явуулж ирснийг болон явуулж байгаа зарим иргэн, улс төрийн нам өмнө нь Улсын дээд шүүхэд мэдэгдэж, тараах шийдвэр гаргахыг хүссэн байдаг боловч нотлогдоогүй байна гэдэг үндэслэлээр удаа дараа буцаагдсан байх бөгөөд Улс төрийн намын тухай хуульд аливаа нам тарах болзол хангасныг хэн, хэрхэн нотлохыг нээлттэй орхижээ.

Үүний учир эдүгээ төрийн эрхийг хэрэгжүүлж байгаа Монгол ардын намын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, холбогдох бусад хуулийг илэрхий зөрчсөн, зүй бус үйл ажиллагааг нотлох чадамж, асуудлыг хуулийн дагуу тавьж шийдвэрлүүлэх боломж нь гагцхүү Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүнд хадгалагдаж байна хэмээн үзэж, ийнхүү хандлаа.

Улс төрийн намыг бүртгэх, бүртгэлээс хасах, тараах шийдвэр гаргах нь Улсын дээд шүүхэд харьяалуулсан Улсын бүртгэлийн /захиргааны/ үйл ажиллагаа, түүний хүрээнд олгогдсон эрх хэмжээ тул Үндсэн хуулиар хамгаалсан, хөндлөнгөөс нөлөөлөхгүйгээр хуульчилсан шүүх эрх мэдлийн “шүүн таслах” үйл ажиллагаатай холбон авч үзэхгүй байх нь зөв гэж үзэж байна.

Түүнчлэн Монгол ардын намын Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах /авсан/ 60 тэрбумын хэргийг хууль, шүүхийн байгууллага нотолж, гэм буруутай этгээдүүдэд хариуцлага хүлээлгэсэн нь хөдөлшгүй баримт болон үлдсэнийг онцлон тэмдэглэе.

Хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ үү.

Нотлох баримт хуудастай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА